



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/132

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 20 дугаар зүйлийн 20.1.10, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9.3 зугаар зүйлийн 9.3.1, 9.4 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төв доторх нийтийн зорчигч тээвэр /такси/-ийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйл ажиллагааг шалгах, осол, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Хуягбаатар – (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Х.Тайванбаяр – (Мөрөн сумын Засаг дарга)

А.Алтанцоож – (Аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Ө.Баттулга – (Авто тээврийн төвийн дарга)

Нарийн бичгийн дарга:

Ё.Ариунзаяа – (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн авто тээврийн хяналтын улсын ахлах байцаагч)

2. Хяналт шалгалтыг удирдамж, хуваарийн дагуу зохион байгуулж, танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

